



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

「Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой, 59,900,000.00 (тавин есөн сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 6,000,000.00 (зургаан сая) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэгт дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

123007522
2-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛГЭЙ,
ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГГҮЙ, АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАЖ ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтанд орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)		Цаашид ашиглах хугацаа /жилээр/	
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт-үнэ (төгрөг)		
1	Автомашин Nissan teana 08-52 УНУ	6/8/2016	59,900,000.00	1	59,900,000.00	6,000,000.00	1	6,000,000.00	2
	НИЙТ ДҮН			1	59,900,000.00 (тавин есөн сая есөн зуун мянга)		1	6,000,000.00 (зургаан сая)	